



# Эл Си Би ХХК

БАРИЛГА УГСРАЛТ, ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭЛ

2501549 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо  
Махатил Ганджин гудамж, MSN building 400 тоот

Утас: +976-11-10483, +976-9962191  
И-мэйл: elsiabi@elbi.com

## Завхан аймгийн Тэс сумын ерөнхий боловсролын сургуульд

Техникийн нөхцөл олгох тухай

1. Хэрэглэгчийн нэр хаяг: Спорт зал
2. Хэрэглэгчийн байршил: Завхан аймгийн Тэс сум
3. Дулааны техникийн нөхцөл.

### Дулааны хэрэглээ

3.1.1. Халаалт: ккал/цаг

3.1.2. Манай байгууллага цэвэр усаар хангах тусгай зөвшөөрөлгүй тул хэрэгцээний халуун, хүйтэн усаар хангах боломжгүй.

3.2 Гадна шугамын холболт хийх байршил, өндөржилт, шугамын диаметр:

ДХ-9-өөс 160 хүүхдийн хичээлийн байрны зүүн талын ДХ-10-н хоорондох  $\phi 50$  шугамыг  $\phi 76$ -н шугам болгож өргөтгөх, шинээр барих спорт залыг ДХ-10-аас  $\phi 63$ -аас багагүй голчтой дулаалгатай ган хоолойгоор сувагжилт дотор холболт хийнэ.

3.3 Дор дурдсан техникийн даалгаврын дагуу зураг төслийг хийх.

3.3.1. Гадна дулааны шугамыг пенопласт болон пенополиуретан материалаар

дулаалж сувагт байрлуулахаар зураг төсөлд тусгах

3.3.2 Төлөвлөж буй барилгын халаах хэрэгсэлд тохируулга вентиль суурилуулахаар зурагт тусгах

3.3.3 Таслах хаалт гагнадаг бөмбөлгөн хаалт байх

3.3.4 Ус юүлэгч хий авагчтай байх


3.3.5 ДХ-9-аас ДХ-10 худаг хүртэлх шугамыг өргөтгөх зардлыг зураг төсөвт тусгах

4. Барилга болон шугам сүлжээ хоорондын зайг холбогдох норм дүрмийн шаардлагыг

хангахаар барилгын зураг төсөл зохиох.

5. Гадна шугам сүлжээ ба дотор системийн угаалга, усан шахалт, туршилтын зардлыг зураг төсөвт тусгах.

Дулааны инженер:



Б.Ширхэрүгэ



БАТЛАВ: Увс "Цахилгаан Түгээх Сүлжээ" ХХК ний гүйцэтгэх захирал  
Ц. Эрдэнэбаатар

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №40/2020/

Огноо 2020.03.10

1. Хэрэглэгчийн нэр, хаяг: Спорт заалны барилга, Завхан аймаг Тэс сум
  2. Хэрэглэгчийн байршил: Завхан аймаг Тэс сум
  3. Ажил үйлчилгээний зориулалт: Нийтийн үйлчилгээ
  4. Техникийн нөхцөл олгох үндэслэл: **Захирал Н.Пүрэвдорж-н хүсэлт**
  5. Суурилагдсан чадал: 16кВт
  6. Шитний байрлал ба тоноглол: Тоолуур хэмжих хэрэгсэлүүд нь Монгол улсын стандартын шаардлагууд бүрэн хангасан байх бөгөөд сүлжээнд холбогдохын өмнө тоолуур хэмжих хэрэгслийг Увс"ЦТС" ХХК-ийн лабораторт шалгуулсан байх шаардлагатай.
  7. Холбогдох цэг: 1. АТП-109 дэд станцын гаргалгааны 14-дахь тулгуураас авах
  8. Тусгай заалтууд: 1. Тоолуур хэмжих хэрэгслийг эзэмшлийн заагт суурилуулах  
2. 0,4кВ-н шит шинээр тоноглох
- А. Энэхүү техникийн нөхцлийн дагуу тавигдах тоноглолууд нь шинэ байх шаардлагатай.  
Б. Заагдсан ачаалалаас илүү хэрэглээ авах үед шинээр техникийн нөхцөл авах  
В. Эзэмшлийн заагт хэмжих хэрэгслийг байрлуулна.  
Г. Зургийг кадастрын зураг дээр гүйцэтгэж Увс"ЦТС" ХХК-д хянуулж баталгаажуулна.  
Д. Техникийн нөхцлийн холболтын схемээр холбогдох  
Е. Дэд станц, тоноглол, шит, тулгуур газардуулж г-назардуулгыг норм дүрмийн дагуу хийж эрх бүхий компаниар шалгуулан протокол үйлдэж баталгаажуулсан байх  
Ё. Барилга байгууламжийг ЭХЯ-с олгосон 03.2.2-р заалтын **тусгай зөвшөөрөлтэй компаниар гүйцэтгүүлж, Увс "ЦТС"ХХК-д хянуулах**  
Ж. Орчны  $\pm 45^{\circ}$  температурт тохирсон тоноглолууд суурилуулах
9. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:
    - 9.1. Хүчдлийн түвшингийн  $\pm 5$  –ийн хэлбэлзлэлд зохицсон тоноглол сууриллуулах
    - 9.2. Монгол улсын Эрчим хүчний тухай хууль, Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм", ЭХЗГ-ын зохицуулагчдын 2002 оны 68 дугаар тогтоолын долдугаар хавсралтаар батлагдсан **"Увс "ЦТС"ХХК-ий холболтын заавар"-ийн заалтыг мөрдлөг болгох**
    - 9.3. Хэрэглэгч өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцна.
    - 9.4. ЭХЗХ-ны 2018 оны 10-р сарын 11-ний өдрийн 289 дугаар тогтоолын 2.13 заалтыг мөрдөх
    - 9.5. Цахилгаан эрчим хүчний тооцоог Увс"ЦТС" ХХК-ийн ХХАТ хийх.
    - 9.6. Цахилгаан эрчим хүч хэрэглэх гэрээг Увс"ЦТС" ХХК-ийн Борлуулалтын албатай хийх.
    - 9.7. Энэхүү техникийн нөхцлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна

Комиссын гишүүд: Ерөнхий инженер ..... Н.Басанхүү  
Техник хяналтын инженер ..... Б.Батзориг  
Ашиглалтын инженер ..... Б.Нямзаяа